

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2018 оны . . . дугаар сарын . . . ны/ий өдрийн . . .  
дугаар тушаалын . . . дугаар хавсралт

## **Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Голомтыг устгах цогц арга ижбүрэн хэрэгжүүлж тухайн халдварт өвчний халдварын голомтыг бүрэн устгасан эсвэл тухайн халдварт өвчний голомтгүй болохыг үндэсний лавлагаа лабораторийн тандан судалгааны үр дүн, эрсдэлийн задлан шинжилгээгээр тогтоож халдварт өвчингүй, тайван байдлыг албан ёсоор баталгаажуулсан аймаг, сум, эрчимжсэн аж ахуйг нийтэд, улсын нийт нутаг дэвгэрийг Дэлхийн амьтын эрүүл мэндийн байгууллагад албан ёсоор мэдээлэхтэй холбогдон гарах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго нь оршино.

1.2. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс нутгаар баталгаажуулж нийтэд мэдээлэхэд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн харилцааг энэхүү журмаар зохицуулна.

### **Хоёр. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтооход тавих ерөнхий шаардлага**

2.1. Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг эсвэл олон улсын худалдааны хоригтой улс орны эдийн засагт ихээхэн хохиролтой халдварт өвчний халдварын голомтыг бүрэн устгах иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлж халдварын голомтыг устгасан тухай мэдээлэл нь Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим санд бүртгэгдсэн байна.

2.2. Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг эсвэл олон улсын худалдааны хоригтой улс орны эдийн засагт ихээхэн хохиролтой халдварт өвчний халдварын голомтгүй болохыг улсын хэмжээнд халдварт өвчнийг тандах төлөвлөгөөнд тусгасан тогтоож мэдээлэлийг Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим санд бүртгэгдсэн байна.

2.3. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг бүрэн хяналтандаа авч, малын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн цахим систем хэрэгжүүлсэн байна.

2.4. Тухай нутаг дэвсгэр дэх өвчлөмтгий болон тээгч болж болзошгүй зэрлэг амьтны хөдөлгөөнд хяналт тавих, тандан судлах арга хэмжээг халдварт өвчнийг хяналтандаа авах төлөвлөгөөнд тусгаж жил бүр үр дүнд нь эрсдэлийн дүн шинжилгээ хийлгэсэн байна.

2.5. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоож баталгаажуулах хүсэлттэй аймаг, нийслэл, сум, дүүрэг, эрчилжсэн аж ахуй нь тухайн халдварт өвчнийг хяналтандаа авах дэд төлөвлөгөөг баталж бүрэн хэрэгжүүлдэг байна.

2.6. Халдварын голомтгүй тайван байдлыг тогтоолгох өвчний тандалт судалгааг улсын хэмжээнд халдварт өвчнийг тандах төлөвлөгөөнд тусгуулан 3-с доошгүй жил

хийлгэж үр дүнд нь аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагаар эрсдэлийн дүн шинжилгээ хийлгэсэн байна.

**Гурав. Монгол Улсын нутаг дэвсгэрийг олон улсын худалдааны хоригтой халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоох хүсэлт гаргах**

3.1. Мал, амьтныг эрүүлжүүлэх талаарх Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх, импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор олон улсын худалдааны хоригтой өвнөөр тайван байдлыг улсын нийт нутаг дэвсгэр, бүс, тусгаарласан аж ахуйгаар импортлогч тал болон Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагад зарлана.

3.2. Халдварт өвчингүй, тайван байдлыг импортлогч талд болон Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагад баталгаажуулах ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газар зохион байгуулна.

3.3. Тухай тайван байдлыг баталгаажуулах халдварт өвчний халдварын голомтгүй болохыг тогтоох тандан судалгаа хийх мэргэжлийн багийг малын ерөнхий эмч томилон Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагын баталсан заавар, зөвлөмжийн дагуу тандан судалгаа хийнэ.

3.4. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагын баталсан заавар, зөвлөмжийн дагуу тайван байдлыг тогтоох тандан судалгааны Мэргэжлийн зөвлөлд танилцуулж малын ерөнхий эмч импортлогч оронд эсвэл Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагад хүргүүлнэ.

3.5. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага, импортлогч орны шинжээч урьж ажиллуулах, дүгнэлт гаргуулахтай холбогдон гарах зардлыг урьдчилан тооцож улсын төсөвт тусгана. Хандивлагч байгууллага, импортлогч орны зардлаар гүйцэтгэж болно.

**Дөрөв. Халдварт өвчингүй, тайван байдлыг аймаг, бүс нутаг, эрчимжсэн аж ахуйгаар тогтоолгох хүсэлт гаргах**

4.1. Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг эсвэл олон улсын худалдааны хоригтой улс орны эдийн засагт ихээхэн хохиролтой халдварт өвчний халдварын голомтыг бүрэн устгасан эсвэл халдварын голомтгүй болохыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар сум, дүүргээр болон эрчимжсэн аж ахуйгаар тогтоолгох хүсэлтээ Мал эмнэлгийн ерөнхий газарт дараахь бичиг баримтыг бүрдүүлж хүргүүлнэ. Үүнд:

4.1.1. Тухай халдварт өвчнөөр тайван байдлыг тогтоолгох үндэслэлээ нотлох баримтын хамт ирүүлэх,

4.1.2. Халдварт өвчнийг хяналтандаа авах төлөвлөгөөнд тухайн тайван байдлыг тогтоолгох өвчний халдварын голомтыг утсгах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан,

4.1.3. Тухайн халдварт өвчнөөр тайван байдлыг тогтоолгох зорилгоор сүүлийн 3-с доошгүй жил улсын хэмжээнд халдварт өвчнийг тандах төлөвлөгөөнд тусгуулан тандан судалгаа хийсэн дүнд эрсэдлийн задлан шинжилгээ хийсэн тайлан,

4.1.4. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоолгох нутаг дэвсгэрийн хилийн заагийг GPS-р тогтоосон зураглал,

4.1.5. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг бүрэн хяналтандаа авсныг нотлож малын эрүүл мэндийн цахим бүртгэлийн архивыг сүүлийн 3-с доошгүй жилийн шилжилт хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл

4.1.6. Зэрлэг амьтны хөдөлгөөн, өвчлөмтгий байдалд тандан судалгааны сүүлийн 3-с доошгүй жилийн тайлан,

4.2. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоолгох хүсэлтийг эхний хагас жилд багтаан Мал эмнэлгин ерөнхий газар ирүүлнэ.

4.3. Халдварт өвчингүй, тайван байдлыг баталгаажуулахтай холбогдон гарах зардлыг тухай хүсэлт гаргасан аймаг, нийслэл, эрчимжсэн аж ахуй бүрэн хариуцна.

#### **Тав. Халдварт өвчингүй, тайван байдлыг баталгаажуулах, мэдээлэх, цуцлах**

5.1. Монгол улсын нийт нутаг дэвсгэр, бүс, тусгаарласан аж ахуйг мал, амьтнаас хүнд халдварладаг болон олон улсын худалдааны хоригтой халдварт өвчнөөр тайван байдлыг тогтоосон тухай Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага, импортлогч орны эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан ёсны бичиг баримтыг үндэслэн Мал эмнэлгийн ерөнхий газар тайван байдлыг нийтэд мэдээлж баталгаажуулна.

5.2. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага, импортлогч оронд халдварт өвчингүй тайван байдлаа баталгаажуулах тандан судалгааг зааврын дагуу тогтоосон хугацаанд хийж холбогдох тайланг хүлгүүлэх ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газар хариуцна.

5.3. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага, импортлогч орны эрх бүхий байгууллагаас тогтоосон халдварт өвчингүй, тайван байдлыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.4. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоогох хүсэлтийн дагуу Малын ерөнхий эмч шинжээчийн баг томилж нарийвчилсан эрсэдлийн задлан шинжилгээ хийнэ. Шинжээчийн баг дараахь эрсэдлийн задлаг шинжилгээг хийнэ. Үүнд:

5.4.1. Хүсэлт гаргагчаас ирүүлсэн бичиг баримтад үнэн бодит эсэхэд үнэлэлт дүгнэлт өгнө.

5.4.2. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоолгох нутаг дэвсгэр, эрчимжсэн аж ахуйн тархвар зүйн байдалд үнэлгээ өгөх ажлыг газар дээр нь гүйцэтгэнэ.

5.4.3. Тухай халдварт өвчний тандалт судалгаа хийх зааварт заасны дагуу тохиолдолын тандан судалгаа хийх шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, шинжилгээний дүнд үнэлгээ өгнө.

5.4.4. Хүсэлт гаргасан нутаг дэвсгэр, эрчимжсэн аж ахуй нь бүхэлдээ болон хэсэгчилсэн байдлаар тайван байдлыг тогтоох эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргана.

5.4.5. Халдварт өвчингүй, тайван байдлаа тогтоолгосон нутаг дэвсгэр, эрчимжсэн аж ахуй тайван байдлаа хадгалах стратегийг боловсруулна.

5.5. Шинжээчийн багийн дүгнэлт, Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн халдварт өвчингүй, тайван байдлыг аймаг, нийслэл, сум, дүүрэг, эрчимжсэн аж ахуйгаар малын ерөнхий эмч олон нийтэд зарлан мэдээлж батламж олгоно.

5.6. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоосон батламжийн загвар, олгох зааврыг Малын ерөнхий эмч батална.

5.7. Халдварт өвчингүй, тайван байдлаа хадгалах стратегийн дагуу хийгдсэн тандалт судалгаагаар болон мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөр өвчний голомтын тохиолдол илэрсэн нь үндэсний лавлагаа лабораторийн шинжилгээгээр батлагдсан тохиолдолд Малын ерөнхий эмчийн шийдвэрээр ажлын 5 өдөрт багтаан цуцалж нийтэд зарлан мэдээлнэ.

5.8. Халдварт өвчингүй, тайван байдлаа цуцлуулсан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар халдварын голомтыг бүрэн устгасан арга хэмжээний тайлан, тайван байдлаа сэргээх тухай хүсэлтээ Мал эмнэлгийн ерөнхий газарт дахин илгээнэ.

5.9. Тайван байдлаа сэргээлэх хүсэлтийнш хүлээн авсан Малын ерөнхий эмч дахин шинжээчийн баг томилон ажиллуулж, дүгнэлтийг үндэслэн халдварт өвчингүй, тайван байдлыг дахин сэргээнэ.

### **Зургаа. Халдварт өвчингүй, тайван байдлын хяналт, тандан судалгаа**

6.1. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага, импортлогч орны эрх бүхий байгууллагад халдварын голомтгүй, тайван байдлыг тогтоолгосон халдварт өвчнийг хяналтандаа авах, хянах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газар хариуцна.

6.2. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага, импортлогч орны эрх бүхий байгууллагад халдварын голомтгүй, тайван байдлыг тогтоолгосон халдварт өвчний тайван байдлыг баталгаажуулах тандалт судалгааг зааврын дагуу үндэсний лавлагаа лаборатори хийнэ.

6.3. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын хүсэлтээр халдвартын голомтгүй, тайван байдлыг тогтоосон халдварт өвчнийг хяналтандаа авах, хянах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох ажлыг тухайн аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар хариуцна.

6.4. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар тайван байдлаа тогтоолгосон халдварт өвчнийг хяналтанд авах төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг орон нутгийн төсөвт тусгуулж хэрэгжүүлнэ.

6.5. Тайван байдлыг тогтоосон халдварт өвчнөөр өвчлөмтгий болон тээгч зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнийг хяналтанд авч, жил бүр заавры дагуу тандан судалгаа хийнэ.

6.6. Халдварт өвчингүй, тайван байдлаа тогтоолгосон эрчимжсэн аж ахуй тайван байдлыг баталгаажуулах тандалт судалгаанд тогтоосон хугацаанд малаа бүрэн хамруулж, гарах зардлыг хүрэн хариуцна.

6.7. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоосон нутаг дэвсгэр, эрчимжсэн аж ахуйд хийх тандалт судалгааг баталсан зааврын дагуу тогтоосон хугацаанд хийж үндэсний лавлагаа лабораториор баталгаажуулсан байна.

6.8. Халдварт өвчингүй, тайван байдлыг баталгаажуулсан нутаг дэвсгэр, эрчимжсэн аж ахуйд хийх тандалт судалгаа болон мал, амьтны шилжилт хөдөлгөөнд сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасаг хяналт тавина.

6.9. Тандалт судалгааны анхан шатны бүртгэл, малын шижилт хөдлөгөөний бүртгэл сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасагт архивлагдан хадгалагдана.

**Долоо. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоосон бүс нутаг, аж ахуйд хориглох үйл ажиллагаа**

7.1. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоосон бүс нутаг, аж ахуйд дараахь үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

7.1.1. Тухайн халдварт өвчний тандан судалгаанд мал амьтнаа тогтоосон хугацаанд хамруулахаас зайлсхийх,

7.1.2. Тайван байдлыг тогтоосон халдварт өвчнийг илрүүлэх шинжилгээ хийлгээгүй өвчлөмтгий мал амьтан тухайн бүс нутаг, аж ахуйд нэвтрүүлэх, хөлөөр дамжуулах өнгөрүүлэх, дамжин өнгөрч буй мал, амьтныг тээврийн хэрэгслээс буулгах,

7.1.3. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр тайван байдлыг тогтоосон бүс нутаг, аж ахуйгаас гадагш отор нүүдэл хийх, тухайн өвчнийг илрүүлэх шинжилгээ хийлгэж үр дүн нь гараагүй байхад нутаг дэсвгэртээ буцаж нэвтрэх,

7.1.4. Тайван байдлыг тогтоосон бүс нутаг, аж ахуйд тухай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин хэрэглэх,

7.1.5. Тус нутаг дэвсгэр, эрчимжсэн аж ахуйд эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй үржүүлгийн бүтээгдэхүүн хэрэглэх,

**Найм. Хариуцлага**

8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухайд заасан шийтгэл ногдуулна.